ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 7-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2024/136/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2024 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор: Г.Ганбилэг<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:ganbilegg@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт.......... 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..........5-10

3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..........10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.......... 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..........10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..........10

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 11

4. Аудитын тайлан..........13

4.1 Ерөнхий зүйл ..........13

4.2 Материаллаг байдал ..........13

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..........13

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........13

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........14

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........14

5. Аудитын илрүүлэлт ..........14

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..........15


## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| БШУГ | Боловсрол шинжлэх ухааны газар |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.23 № 203

танай__________-ны №__________-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН
СУМЫН 7-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.НАНСАЛМАА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 7-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 7-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

## Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, үйл явдал гараагүй байна.

## Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 7-р цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 8 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Боловсрол шинжлэх ухааны газраас 92 хувиар дүгнэсэн байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0110?1097

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **96,518,189.23** | **187,409,030.90** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 22,405,767.12 | 98,739,299.29 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 22,405,767.12 | 98,739,299.29 |
| **3121** | **Төгрөг** | 22,405,767.12 | 98,739,299.29 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 22,405,767.12 | 98,739,299.29 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 74,112,422.11 | 88,669,731.61 |
| **354** | **Хангамжийн материал** | 74,112,422.11 | 88,669,731.61 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,786,655.00 | 7,786,655.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 66,325,767.11 | 80,883,076.61 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,356,963,858.38** | **1,353,183,609.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,356,963,858.38 | 1,353,183,609.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,231,963,858.38 | 1,228,183,609.98 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,286,388,013.15 | 1,315,179,397.15 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -98,499,150.72 | -123,123,938.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,365,794.00 | 35,365,794.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17,374,713.51 | -22,369,581.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,857,534.00 | 40,857,534.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -30,823,618.54 | -33,550,595.26 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,950,000.00 | 16,950,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -900,000.00 | -1,125,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 125,000,000.00 | 125,000,000.00 |
| 39301 | Программ хангамж | 1,116,500.00 | 1,116,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,116,500.00 | -1,116,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 125,000,000.00 | 125,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,453,482,047.61** | **1,540,592,640.88** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,453,482,047.61** | **1,540,592,640.88** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,453,482,047.61 | 1,540,592,640.88 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 125,000,000.00 | 125,000,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 125,000,000.00 | 125,000,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 996,897,347.61 | 1,084,007,940.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 978,428,305.62 | 996,897,347.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 18,469,041.99 | 87,110,593.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 331,584,700.00 | 331,584,700.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,453,482,047.61** | **1,540,592,640.88** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **494,562,800.00** | **679,756,713.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **25,521,400.00** | **34,273,713.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 25,521,400.00 | 34,273,713.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 20,657,000.00 | 28,791,384.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469,041,400.00** | **645,483,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 423,940,300.00 | 616,468,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 423,940,300.00 | 616,468,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 44,901,100.00 | 29,015,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,901,100.00 | 29,015,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **476,093,758.01** | **592,646,120.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,093,758.01** | **592,646,120.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 471,907,360.01 | 592,643,077.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,444,325.05 | 383,568,431.02 |
| 210101 | Үндсэн цалин | 230,142,616.05 | 282,616,068.24 |
| 210102 | Нэмэгдэл | 59,403,819.00 | 88,296,991.98 |
| 210104 | Урамшуулал | 14,897,890.00 | 12,655,370.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,770,174.83 | 48,120,001.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,452,947.01 | 33,779,627.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,117,074.15 | 3,974,072.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,440,659.28 | 3,126,458.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523,436.88 | 651,715.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,236,057.51 | 6,588,128.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,990,145.00 | 28,511,957.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,763,697.00 | 4,562,016.71 |
| 210302 | Түлш, халаалт | 10,263,499.00 | 12,619,360.67 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,962,949.00 | 11,330,579.88 |
| **2105** | **Нормативт зардал** | 62,162,100.00 | 85,583,035.00 |
| 210502 | Хоол, хүнс | 62,162,100.00 | 85,583,035.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 924,600.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 924,600.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 952,900.00 | 870,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 952,900.00 | 870,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,663,115.13 | 45,989,652.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,034,740.00 | 10,656,720.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,300,000.00 | 2,761,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,328,375.13 | 32,571,632.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,186,398.00 | 3,042.74 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,986,398.00 | 3,042.74 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,986,398.00 | 3,042.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **18,469,041.99** | **87,110,593.27** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **18,469,041.99** | **87,110,593.27** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **469,041,400.00** | **645,483,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **469,041,400.00** | **645,483,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 423,940,300.00 | 616,468,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 423,940,300.00 | 616,468,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 44,901,100.00 | 29,015,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,901,100.00 | 29,015,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **446,635,632.88** | **569,149,467.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **446,635,632.88** | **569,149,467.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **442,449,234.88** | **569,146,425.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 304,444,325.05 | 383,568,431.02 |
| 210101 | Үндсэн цалин | 230,142,616.05 | 282,616,068.24 |
| 210102 | Нэмэгдэл | 59,403,819.00 | 88,296,991.98 |
| 210104 | Урамшуулал | 14,897,890.00 | 12,655,370.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,770,174.83 | 48,120,001.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,452,947.01 | 33,779,627.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,117,074.15 | 3,974,072.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,440,659.28 | 3,126,458.01 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523,436.88 | 651,715.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,236,057.51 | 6,588,128.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,990,145.00 | 28,511,957.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,763,697.00 | 4,562,016.71 |
| 210302 | Түлш, халаалт | 10,263,499.00 | 12,619,360.67 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,962,949.00 | 11,330,579.88 |
| **2105** | **Нормативт зардал** | 62,162,100.00 | 85,583,035.00 |
| 210502 | Хоол, хүнс | 62,162,100.00 | 85,583,035.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 924,600.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 924,600.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 952,900.00 | 870,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 952,900.00 | 870,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,204,990.00 | 21,993,000.04 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,904,990.00 | 17,818,700.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,300,000.00 | 4,174,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,186,398.00** | **3,042.74** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,986,398.00 | 3,042.74 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **22,405,767.12** | **76,333,532.17** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 22,405,767.12 | 76,333,532.17 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 22,405,767.12 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 22,405,767.12 | 98,739,299.29 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **125,000,000.00** | **331,584,700.00** | **996,897,347.61** | **00.00** | 1,453,482,047.61 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **125,000,000.00** | **331,584,700.00** | **996,897,347.61** | **00.00** | 1,453,482,047.61 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **125,000,000.00** | **331,584,700.00** | **996,897,347.61** | **00.00** | 1,453,482,047.61 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 87,110,593.27 | 00.00 | 87,110,593.27 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **125,000,000.00** | **331,584,700.00** | **1,084,007,940.88** | **00.00** | 1,540,592,640.88 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 22,405,767.1 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 667,872,500.0 | 569,149,467.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 667,872,500.0 | 569,149,467.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 667,872,500.0 | 569,146,425.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 467,556,400.0 | 383,568,431.0 |
| 210101 | Үндсэн цалин | 318,496,900.0 | 282,616,068.2 |
| 210102 | Нэмэгдэл | 138,079,400.0 | 88,296,992.0 |
| 210104 | Урамшуулал | 10,980,100.0 | 12,655,370.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,444,700.0 | 48,120,001.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,742,300.0 | 33,779,627.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,675,900.0 | 3,974,072.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,740,600.0 | 3,126,458.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 935,000.0 | 651,715.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,350,900.0 | 6,588,128.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,515,000.0 | 28,511,957.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,353,200.0 | 4,562,016.7 |
| 210302 | Түлш, халаалт | 11,489,000.0 | 12,619,360.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,672,800.0 | 11,330,579.9 |
| **2105** | **Норматив зардал** | 89,471,900.0 | 85,583,035.0 |
| 210503 | Хоол, хүнс | 89,471,900.0 | 85,583,035.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.0 | 500,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.0 | 500,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,391,400.0 | 870,000.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,391,400.0 | 870,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,993,100.0 | 21,993,000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,818,800.0 | 17,818,700.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,174,300.0 | 4,174,300.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 3,042.7 |
| 213102 | Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,042.7 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 667,872,500.0 | 645,483,000.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 638,857,500.0 | 616,468,000.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 29,015,000.0 | 29,015,000.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 29,015,000.0 | 29,015,000.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 22,405,767.1 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 98,739,299.3 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 25.5 | 25.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.0 | 17.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.5 | 7.5 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 350.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*
Хүнсний агуулахад хийлгэсэн 2.2 м урттай, 1.7 м өргөнтэй 12 тасалгаатай модон тавиурыг 350.0 мянган төгрөгөөр шууд зардалд бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

Аудитаар нийт 676.5 мянган төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

1. “Ихханас” ХХК-аас 275.0 мянган төгрөгийн бэлэн байдлын хар хослол, 82.5 мянган төгрөгийн аранз нийт 357.5 мянган төгрөгийн ажлын хувцас бэлтгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

2. Арга зүйч албан тушаалд шилжин ажилласан багшид 4, 5 дугаар сарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшууллалд 319.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмын 4 дүгээр зүйлийн 4.9-т “Багш нэмэгдэл авч байх хугацаандаа багш бус ажилд шилжин ажилласан тохиолдолд төрөөс санхүүжүүлэх урамшууллыг зогсооно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ихханас ХХК- | 1 | 357.5 | 1 | 357.5 | | | | | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| аас 275.0 мянган төгрөгийн бэлэн байдлын хар хослол худалдан авсан байна.. | | | | | | | | | | | | | |
| Арга зүйч албан тушаалд шилжин ажилласан багшид 4, 5 дугаар сарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшууралд 319.0 мянган төгрөг олгосон байна | 1 | 319.0 | 1 | 319.0 | | | | | | | | | |
| Дүн | 2 | 676.5 | 2 | 675.5 | | | | | | | | | |